**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД**

**ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМААС БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ**

**БЯМБАСҮРЭН ОВОГТОЙ ЭНХБОЛДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Зорилго: Завхан аймгийн хөгжлийн үзэл баримтлалыг шинээр тодорхойлж, эрүүл, аюулгүй амьдралын таатай орчин бүрдүүлсэн олон нийтийн идэвхтэй оролцоонд тулгуурласан сайн засаглал бүхий бүтээлч, баялаг бүтээгч аймаг болгон хөгжүүлнэ.

Үүний тулд доорхи ажлуудыг гүйцэтгэж зохион байгуулна.

1. Аймгийн төвийн дэд бүтцийн инженерийн шийдлийг гаргаж нэгдсэн халаалт, цэвэр, бохир усыг шийдэх дулааны цахилгаан станцыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2024 онд шийдвэрлэнэ.
2. Өрхийн хэрэглээний хүнсний ногоо, Хүлэмжийн ногооны тариалалтыг орон нутгийн бодлогоор дэмжиж иргэдийн жилийн хүнсний ногооны дийлэнх хувийг дотоод тариалалтаараа хангадаг болно.
3. Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг сайжруулах, алсын дуудлагын чанар хүртээмжийг сайжруулна.
4. Малын үржил , слекцийн ажлыг шинэ шатанд гаргаж гараар хээлтүүлэг хийх, онц гойд ашиг шимт эцэг малаар хээлтэгч малыг хээлтүүлэх замаар хурдны болон махны адуу, махны хонь, сүү махны үхэр сүргийг бий болгож нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг хүн амын зорилтод бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.
6. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалттай газарт оруулах арга хэмжээ авна.
7. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалж хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
8. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хяналт тавьж ажиллана.
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг хүн амын зорилтод бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.
10. Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж дотоодын аялал жуулчлалыг олон улсын стандартын дагуу хөгжүүлж ажлын байр иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ

БОЛОВСРУУЛСАН: ...................................... Б.ЭНХБОЛД / УТАС:98982626/

НЭР ДЭВШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ: М.ДАШЗЭВЭГ / УТАС:98117687/